

ГОВЬСҮМЭР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗАР

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2016/4





www.1212.mn



**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН**



www.nso.mn сайтын
Хэрэглэгийн бүртгэлд
бүртгүүлснээр
цахим хаягаар
тогтмол авч болно.



Monstat ezStat
аппликейшн



1900-1212



Лавлах утас

**Үндэсний
Статистикийн
хорооны
НОМЫН САН**

@statistic_mn



Статистик
мэдээлэл



Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВЛИГА

ҮГҮЙ

НЭЭЛТТЭЙ

ХҮРГЭНЭ



ГАРЧИГ

- Ерөнхий тэмдэглэл
- Аргачлалын тайлбар.....
- I.Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III.Эрүүл мэнд
- IV.Гэмт хэрэг
- V.Үнэ.....
- VI.Төсөв.....
- VII.Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IXI.Тээвэр.....
- XI. Холбоо.....
- XII.Цаг агаарын мэдээ.....
- Хавсралт.....



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараахь тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

• Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

• Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.



✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.**

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.**

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэрхэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг гнэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.



✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг СанхүүТөрийн сангийн Хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны 4 дүгээр сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 4 дүгээр сард 348 байгаагийн 193 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63 буюу 15.3 хувиар буурч, өмнөх сарынхаас 62 буюу 21.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эхний 4 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 66 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеэс 4 буюу 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөрийн хэлтсээр эхний 4 сард 25 иргэн ажилд зуучлуулсны 17 нь буюу 68.0 хувь эмэгтэйчүүд байлаа.

Зураг.I.1

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй,
жил бүрийн эхний 4 дүгээр сарын байдлаар



Ажил хайгч иргэдийн 50.3 хувийг бүрэн дунд, 17.2 хувийг дипломын болон бакалаврын, 13.2 хувийг техникийн болон мэргэжлийн, 7.2 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.9 хувийг суурь, 3.5 хувийг бага боловсролтой, 1.7 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.



I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэл, статистикийн газрын Бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 144 эх амаржиж, 145 хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 17 буюу 13.4 хувиар, төрсөн хүүхдийн тоо 17 буюу 13.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нас баралт 34, бүртгүүлсэн гэр бүл 25, цуцалсан гэр бүл 5, үрчлэгдсэн хүүхэд 3 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс нас баралт 6 буюу 21.4 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 1 буюу 4.2 хувиар тус өсч, цуцалсан гэр бүл 4 буюу 44.4 хувиар буурсан бол үрчлэгдсэн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд байна.

Тайлант хугацаанд 352 иргэн нийслэл болон бусад аймгуудаас шилжин ирж, 256 иргэн нийслэл болон бусад аймаг руу шилжин явсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн иргэн 175 буюу 98.9 хувиар, шилжин явсан иргэн 121 буюу 89.6 хувиар тус тус өссөн байна.

Зураг.I.3

Шинэ төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 4 дүгээр сард 1996.5 сая төгрөг, зарлага 2754.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 345.7 сая төгрөг буюу 14.7 хувиар буурч, зарлага 54.4 сая төгрөг буюу 2.0 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 4 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 345.7 сая төгрөгөөр буурахад ажилгүйдлийн орлого 413.6 сая төгрөг буюу 92.4 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 4 дүгээр сард 2754.3 болж, өмнөх оны мөн үеийнхээс 54.4 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 89.9 сая төгрөг буюу 4.5 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 4 сард 3236 хүнд 465.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 209 хүн буюу 6.9 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 7.1 сая төгрөг буюу 1.5 хувиар тус тус өссөн байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 оны эхний 4 сард 1043 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 19 хүн буюу 1.8 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 16.5 сая төгрөг буюу 6.7 хувиар тус тус буурсан байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжинд 2016 оны эхний 4 сард 2193 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 228 хүн буюу 11.6 хувиар буурч, олгосон халамж үйлчилгээ хөнгөлөлт, тусламж 23.7 сая төгрөг буюу 11.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн эхний 4 сарын мэдээгээр 182 байгууллагын 4831 даатгуулагч иргэн, үүнээс 733 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуудагчдын цалин өссөн дүнгээр 12.8 тэрбум төгрөг байгаа бол сарын дундаж цалин сайн дурын даатгуулагч ороогүй дүнгээр 763.4 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 21 аж ахуй нэгж, байгууллагын 1110 ажилтны дундаж цалин нь 980.9 мянган төгрөг, төсөвт 54 байгууллагын 1505 ажилтны дундаж цалин нь 677.9 мянган төгрөг, 7 ХКомпанийн 615 ажилтны дундаж цалин нь 1066.6 мянган төгрөг, 79 ХХКомпанийн 726 ажилтны цалин дундаж цалин нь 412.9 мянган төгрөг, бусад 21 байгууллагын 142 ажилтны дундаж цалин нь 447.0 мянган төгрөг боллоо.



Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2016 оны эхний 4 дүгээр сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 4 сарын байдлаар 135 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 134 үүнээс 67 нь хүү, 67 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 5 буюу 3.8 хувиар, төрсөн хүүхэд 6 буюу 4.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг III.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 4 сарын байдлаар




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 ба 1000 амьд төрөлтөд 37.0 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.6 промилоор нэмэгдсэн, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй байна /2015 онд 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 ба 1000 амьд төрөлтөд 30.9 промил, 1-5 насанд эндэгдэл, Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй/ 2016 оны 4-р сард гэрийн төрөлт 1 бүртгэгдсэн болно. Халдварт өвчин эхний 4 сарын байдлаар 125



буюу 10000 хүн амд 77.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 100 тохиолдлоор нэмэгдэж, нийт өвчлөлд улаанбурхан өвчин 72.0 хувийг эзэлж байна.

Зураг III.2

Нас баралт, жил бүрийн эхний 4 сарын байдлаар




Он гарсаар 46838 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 12059 буюу 34.7 хувиар, 1755 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 266 буюу 17.9 хувиар тус тус өссөн байна.

2016 оны эхний 4 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 2657 удаа гарч, осол гэмтлийн өвчлөл 290, хадварт өвчин 125 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Осол гэмтлийн болон халдварт өвчний өвчлөл,
жил бүрийн эхний 4 сарынбайдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 4 сард 65 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3 хэрэг буюу 4.4 хувиар буурсан байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо,
жил бүрийн эхний 4 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3 буюу 11.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэргийн тоо 11, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 68.6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс илрээгүй гэмт хэрэг 1 буюу 8.3 хувиар, илрүүлэлтийн хувь 0.9 пунктээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 60 хүн гэмтэж, 8 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 29 буюу 32.6 хувиар буурч, нас баралт 1 буюу 14.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал,
жил бүрийн эхний 4 сарын байдлаар






Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны 4 сарын байдлаар 95.2 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 55.8 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 539.4 сая төгрөг буюу 99.2 хувь, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 128.8 сая төгрөг буюу 69.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 4 сард 296 хүн эрүүлжүүлэгдэж, 6 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 48 буюу 14.0 хувь, баривчлагдсан хүний тоо 51 буюу 89.5 хувиар тус тус буурсан байна.

Зураг IV.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо
жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 2.3 хувь, өмнөх оны эцсийнхээс 2.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.2 хувиар өссөн байна.




Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 4 дүгээр сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2016. IV	2016. IV	2016. IV
	2015. IV	2015. XII	2016. III
Ерөнхий индекс	106.2	102.2	102.3
Хүнсний бараа, ундаа, ус	103.6	108.6	108.5
Согтууруулах ундаа, тамхи	97.7	100.3	100.0
Хувцас, бөс бараа, гутал	111.7	100.0	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	101.9	97.9	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.5	99.8	99.7
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
Тээвэр	98.3	97.6	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	102.7	102.6	102.6
Боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	125.6	111.9	100.0
Бусад бараа, үйлчилгээ	104.3	100.9	100.0

Ерөнхий индекс өмнөх оны мөн үеийнхээс 6.2 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ 32.5 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн үнэ 25.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 4 дүгээр сар, (өмнөх сар=100%)





VI. Орон нутгийн төсөв


2016 оны эхний 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 5105.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 5406.1 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 1512.5 сая төгрөг буюу 38.8 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт зарлага 5331.7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 4184.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 1147.1 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 404.3 сая төгрөг буюу 10.7 хувиар өссөн байна.

2016 оны эхний 4 сарын байдлаар авлагын үлдэгдэл 26.4 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 564.0 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал авлагын үлдэгдэл 24.9 сая төгрөг буюу 17.6 дахин, өглөгийн үлдэгдэл 336.8 сая төгрөг буюу 2.5 дахин өссөн байна.

Зураг VI.1

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн
эхний 4 сарын байдлаар, сая төгрөгөөр




VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлэгч малын 138714 буюу 81.0 хувь нь 2016 оны 4 дүгээр сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 87.6 хувь, эм ямаа 80.4 хувь, үнээний 51.2 хувь, ингэний 34.7 хувь, гүүний 27.8 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 139610 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 20392 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна.


2016 оны эхний 4 сард том малын зүй бус хорогдол 10005 болж, өмнөх оны мөн үеийнхээс 9768 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 2 мал байна.



Төл бойжилт, жил бүрийн эхний 4 сараар, толгойгоор



Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 4 сараар, толгойгоор


**VIII. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 4 сард 15477.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3141.3 сая төгрөг буюу 25.5 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 3045.4 сая төг буюу 26.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 14322.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1139.8 сая төгрөг буюу 8.6 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 14322.5 сая төг буюу 93.3 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар,
жил бүрийн эхний 4 сар, сая төгрөгөөр



IX.ТЭЭВЭР

Авто тээврийн газар 2016 оны эхний 4 сарын мэдээгээр 7.6 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 1655.9 мян.хүн км болж , 13 ажилтантай 3.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.


X. ХОЛБОО

Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 оны эхний 4 сарын байдлаар нийт орлого 68.0 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 9.1 сая төг буюу 11.8 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 40.8 сая төг буюу 40.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 5.4 сая төг буюу 11.8 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт телефон цэгийн тоо 367 болж өмнөх оны мөн үеийнхээс 47 буюу 11.3 хувиарь буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 4 сарын байдлаар интернэт үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 15 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 5 байна.



Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого,
жил бүрийн эхний 4 сар, сая төгрөгөөр



XI. Цаг агаарын мэдээ

2016 оны 4 дүгээр сард 2.3 мм тунадас орж, ихэнх хугацаанд салхи секундэд 6-11 метр байсан ба хамгийн их нь 20.5 м/с хүрсэн. Агаарын температурын хувьд 4 дүгээр сарын нэгдүгээр арав хоногтоо шөнөдөө 4-9 градус хүйтэн өдөртөө 9-14 градус дулаан, хоёрдугаар арав хоногтоо шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан, гуравдугаар арав хоногтоо шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 15-20 градус дулаан байсан. Хамгийн их дулаан нь 4-р сарын 29-нд 20.5 градус дулаан, хамгийн бага нь 4-р сарын 2-нд 9.7 градус хүйтэн байсан байна.

2016 оны 05-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ

Энэ сарын агаарын дундаж температур Говьсүмбэр аймгийн нутгаар 9-14 градус дулаан ба олон жилийн дунджийн орчим байна. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон эцэсээр ширүүсч шөндөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан байна. Хоёрдугаар арав хоногийн дунд үе гурав дугаар арав хонгийн дунд үеээр бага зэрэг сэрүүсч шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан байна. Харин хоёрдугаар арав хонгийн эхэн, гуравдугаар арав хоногийн сүүлийн зарим өдөр шөнөдөө 12-17 өдөртөө 27-32 градус хүрч дулаарах төлөвтэй байна. Бусад хугацаанд шөнөдөө 5-10 градус дулаан, өдөртөө 20-25 градус дулаан байна.



2016 оны 05 сарын хур тунадасны урьдчилсан мэдээ

Энэ сард Говьсүмбэр аймгийн нутгаар олон жилийн дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна. Нэгдүгээр арав хонгийн дунд үеэр хур тунадас орно. Хоёр ба гуравдугаар арав хонгийн дунд болон гуравдугаар арав хонгийн сүүлээр бороо орох төлөвтэй /дуу цахилгаантай/ байна. Салхи нэгдүгээр арав хонгийн эхэн ба дунд үе хоёрдугаар арав хонгийн эхний хагас гуравдугаар арав хонгийн дунд үе болон эцсээр 16-18 м/с, зарим үед 24 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй байна.

ХАА-н үйлдвэрлэлд нөлөөлөх тухай

5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын температур олон жилийн дунджийн орчим, хур тунадас орохоор байна. Цаашид 5-р сард шөндөө жихүүн хүйтэн үе үе хүчтэй шороон шуурга шуурч бэлчээрийн ургамлын ургалтыг удаашруулахын дээр малын хариулга маллагаа болон төл хүлээн авахад хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2015 IV	2016 IV	Зөрүү	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд					
Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)	хүн	128	134	6	104.7
Ажил хайгч иргэдийн тоо, 4 дүгээр сарын эцэст	хүн	255	348	93	136.5
Халдварт өвчнөөр өвчлөгчдын тоо	хүн	25	125	100	5 дахин
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	68	65	-3	95.6
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт					
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	3893.6	5406.1	1512.5	138.8
Татварын орлого	сая.төг	1046.7	1507.6	460.9	144.0
Татварын бус орлого	сая.төг	90.7	170.6	79.9	188.0
Хөрөнгийн орлого	сая.төг	712.2	123.2	-	-
Тусламжийн орлого	сая.төг	2846.2	3604.7	758.5	126.6
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	3780.2	4184.6	404.4	110.7
Бараа үйлчилгээний зардал	сая.төг	3171.8	3545.0	373.2	111.8
Эдийн засгийн үзүүлэлтүүд					
Том малын зүй бусын хорогдол	тол	237	10005	8015	42 дахин
- Тэмээ	тол	-	1	-	-
- Адуу	тол	3	279	276	93 дахин
- Үхэр	тол	7	403	396	57 дахин
- Хонь	тол	93	3628	3535	39 дахин
- Ямаа	тол	134	5694	5560	42 дахин
Бойжуулсан төл	тол	118549	138714	19631	116.6
- Тэмээ	тол	139	128	-16	88.5
- Адуу	тол	1915	1594	-358	81.3
- Үхэр	тол	2166	2576	282	113.0
- Хонь	тол	57049	69532	12849	122.5
- Ямаа	тол	57280	64884	6874	112.0
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	12336.5	15477.8	3141.3	125.4
Тээврийн орлого	сая.төг	-	2.7	-	-
Холбооны орлого	сая.төг	58.0	49.6	-8.4	14.5



I.1 ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Ажил хайгч иргэнийн тоо	411	348	84.7
Үүнээс эмэгтэй	228	193	84.7
Ажлын байрны захиалга	70	66	94.3
Ажилд жуучлагдсан иргэд	35	25	71.4
Үүнээс эмэгтэй	24	17	70.8

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Сангийн төрөл	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	2342.3	1996.5	85.2
Тэтгэврийн даатгалын сангийн	1466.9	1242.9	84.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	165.6	142.0	85.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн	221.1	389.9	176.3
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	40.9	187.7	-
Ажилгүйдлын даатгалын сангийн	447.8	34.1	-
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	2699.9	2754.3	102.0
Тэтгэврийн даатгалын сангийн	1987.3	2077.2	104.5
Тэтгэмжийн даатгалын сангийн	192.0	150.3	78.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	98.2	94.4	96.1
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	59.8	59.0	98.7
Ажилгүйдлын даатгалын сангийн	362.6	373.4	103.0

Тайлбар: *ҮОМШӨ –Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, 2016 оны 4 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 IV		2016 IV		$\frac{2016 IV}{2015 IV} \%$	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	3027	458.4	3236	465.5	106.9	101.5
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1062	247.3	1043	230.8	98.2	93.3
Халамжийн тэтгэвэр	278	124.5	250	113.9	89.9	91.5
Нөхцөлт мөнгөн тэтгэмж / Үүнээс: /	784	122.8	793	116.9	101.2	95.2
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	532	63.0	549	58.6	103.2	93.0
Ахмад настныг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	112	22.2	106	20.8	94.6	93.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний асаргааны тэтгэмж	118	31.8	122	33.4	103.4	105.0
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсөн, асарч буй иргэний тэтгэмж	22	5.9	16	4.2	72.7	71.2
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	1965	211.0	2193	234.7	111.6	111.2
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	387	19.5	609	33.5	157.4	171.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	42	3.2	88	10.7	2 дахин	3 дахин
Нийгмийн халамжийн үйлчилгээ	272	4.7	363	13.8	-	-
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	192	26.7	185	19.5	96.3	73.0
Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	10	6.3	7	4.3	70.0	68.2
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1062	150.7	941	153.0	88.6	101.5



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Төрсөн эх	130	135	103.8
Амьд төрсөн хүүхэд	128	134	104.7
Эрэгтэй	60	67	111.6
Эмэгтэй	68	67	98.5
Амьгүй төрөлт	2	2	100.0
Нийт нас баралт	25	26	104.0
Эмнэлгийн нас баралт	5	5	100.0
Хоног болоогүй нас баралт	3	3	100.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	5	166.6
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	-	-	-
Эмчлэгдсэн өвчтөн	1489	1755	117.9
Амбулаторийн үзлэг	34779	46838	134.7
Осол гэмтлийн өвчлөл	248	290	116.9
Халдварт өвчин	25	125	4 дахин



IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , төрлөөр

Үзүүлэлт	2015 VI	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	68	65	-4.4
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	33	30	-9.1
Өмчлөх эрхийн эсрэг	26	23	-11.5
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	3	4	33.3
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2.2	2.2	0.0
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	1	2	2 нэгж
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	2	2 нэгж
Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	3	0	3 нэгж
Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0	0	0.0
Албан тушаалтны эсрэг гэмт хэрэг	0	1	1 нэгж
Иргэдийн улс төрийн болон бусад эрх эрх чөлөөний эсрэг гэмт	0	0	0.0
Гэмт хэрэгт холбогдогсод	58	63	8.6
14-16 хүртэлх насны	0	1	1 нэгж
16-18 насны	2	3	1 нэгж
18-30 насны	21	34	62.0
30-35 насны	9	12	33.0
35-с дээш	26	13	-50
Боловсрол – Дээд	5	9	80.0
Боловсрол - Тусгай дунд	7	5	-29.0
Боловсрол – Бүрэн дунд	21	28	33.3
Боловсрол – Бүрэн бус дунд	18	11	-38.9
Боловсрол – Бага	5	7	40.0
Боловсролгүй	2	3	1 нэгж
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	9	3	-66.7
Ажилгүй иргэд үйлдсэн	29	36	1 нэгж
Эмэгтэй хүн оролцсон	4	13	9 нэгж
Хүүхэд оролцсон	3	4	33.3
Бүлгээр үйлдсэн	3	7	4 нэгж
Согтуугаар үйлдсэн	33	21	-36.4
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	68	65	-4.4
Гудамж талбайд	22	21	-4.5
Албан газарт	7	5	-28.6
Гэр орон сууцанд	20	24	20.0
Авто зам	3	1	-66.7
Бусад газарт	16	14	-12.5
ГХ-н улмаас нас барсан	7	8	14.3
ГХ-н улмаас гэмтсэн	89	60	2.0
Учирсан хохирол / сая.төг /	634.6	95.2	-85.0
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	184.6	55.8	-69.8



V.1 Хэрэглээний үний индекс, 4 дүгээр сард, 2015.4, 2015.12, 2016.3 дугаар саруудтай харьцуулснаар

Барааны бүлгээр	2016-4 2015-4	2016-4 2015-12	2016-4 2016-3
Ерөнхий индекс	106.2	102.2	102.3
01. хүнсний бараа, согтууруулах бус ундаа	103.6	108.6	108.5
01.1 хүнсний бараа	103.3	108.5	108.9
01.1.1 талх, гурил, будаа	117.6	98.1	100.1
01.1.2 мах, махан бүтээгдэхүүн	94.3	141.8	135.2
01.1.4 сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	99.3	97.1	99.7
01.1.5 төрөл бүрийн өөх, тос	93.6	98.7	102.6
01.1.6 жимс, жимсгэнэ	97.7	96.6	102.0
01.1.7 хүнсний ногоо	98.6	106.7	99.2
01.1.8 саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколад	89.4	93.5	102.1
01.1.9 хүнсний бусад бүтээгдэхүүн	98.5	98.8	100.3
01.2 согтууруулах бус ундаа	110.1	110.0	100.0
02. согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	97.7	100.3	100.0
02.1 согтууруулах ундаа	100.8	100.7	100.0
02.2 тамхи	96.0	100.0	100.0
03. хувцас, бөс бараа, гутал	111.7	100.0	100.0
03.1 хувцас, бөс бараа	110.0	100.0	100.0
03.1.1 хөвөн, бөс бараа	121.3	100.0	100.0
03.1.2 бүх төрлийн хувцас	109.2	100.0	100.0
03.1.3 жижиг эдлэл, хэрэгсэл	123.0	100.0	100.0
03.2 гутал	116.4	100.0	100.0
04. орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	101.9	97.9	100.0
04.1 орон сууцны бодит түрээс	100.0	100.0	100.0
04.2 орон сууцны техникийн болон засварын үйлчилгээ	101.9	99.6	100.0
04.3 усан хангамж болон орон сууцны бусад үйлчилгээ	100.0	100.0	100.0
04.4 цахилгаан, хийн болон бусад түлш	102.2	96.8	100.0
05. гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.5	99.8	99.7
05.1 гэр ахуйн тавилга, хэрэгсэл, хивс болон шалны бусад дэвсгэр	100.7	100.0	100.0
05.2 гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл	99.2	100.0	100.0
05.3 гэр ахуйн цахилгаан бараа	96.8	100.0	100.0
05.4 гэр ахуйн шилэн эдлэл, сав суулга	122.1	100.0	100.0
05.5 гэр ахуй, цэцэрлэгийн зориулалттай хөдөлмөрийн багаж хэрэгсэл	101.1	103.6	100.0
05.6 гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг бараа, гэрийн үйлчилгээ	112.3	98.7	98.7
06. эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.3	100.0	100.0
06.1 эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл	105.0	100.0	100.0
06.2 амбулторын үйлчилгээ	100.0	100.0	100.0
06.3 эмнэлэгт хэвтэж үзүүлсэн үйлчилгээ	100.0	100.0	100.0
07. тээвэр	98.3	97.6	100.0
07.1 тээврийн хэрэгслийн худалдан авалт	100.0	100.0	100.0
07.2 хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	95.1	95.2	100.0
07.3 тээврийн үйлчилгээ	104.4	100.0	100.0
08. холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	100.0	100.0
09. амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	102.7	102.6	100.0
09.1 дуу, дүрс, гэрэл зураг, мэдээллийг боловсруулах тоног төхөөрөмж	100.1	100.0	100.0
09.2 чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	115.0	115.0	100.0
09.3 ном, сонин, бичгийн хэрэгсэл	100.2	100.0	100.0
10. боловсролын үйлчилгээ	132.5	100.0	100.0
11. зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	125.6	111.9	100.0
11.1 нийтийн хоолны үйлчилгээ	120.6	100.5	100.0
11.2 зочид буудал дотуур байрны үйлчилгээ	133.3	133.3	100.0
12. бусад бараа, үйлчилгээ	104.3	100.9	100.0
12.1 хувь хунд хандсан үйлчилгээ	105.1	101.0	100.0
12.2 хувь хүний эд зүйл, хэрэглэл	100.0	100.0	100.0
12.3 санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Орон нутгийн орлого	3893.6	5406.1	138.8
Татварын орлого	1046.7	1507.5	144.0
Орлогын албан татвар	776.2	882.5	113.6
Өмчийн татвар	103.2	31.6	30.6
Үүнээс Дотоодын бараа үйлчилгээний	-	-	-
Бусад	167.2	593.3	354.8
Татварын бус орлого	90.7	170.6	188.0
Хөрөнгийн орлого	712.2	123.2	17.2
Тусламжийн орлого	2846.2	3604.7	126.6

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Бүх зарлага	3780.2	4184.5	110.7
Бараа үйлчилгээний зардал	3171.8	3545.0	111.8
Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал	-	339.7	-
Хөрөнгийн зардал	-	299.7	-
Төсөвт байгууллагын тоо	47	51	108.5
Төсөвт байгууллагын ажиллагсадын тоо	751	769	102.4

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Авлага	1.0	26.4	26 дахин
Өглөг	227.3	564.0	2 дахин



VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Төрөл	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Бүгд	118468	138714	117.0
Ингэ	142	128	90.1
Гүү	1928	1594	82.7
Үнээ	2181	2576	118.1
Эм хонь	56973	69532	122.0
Эм ямаа	57244	64884	113.3

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Сумд	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Дүн	118468	138714	117.0
Баянтал	19439	22350	115.0
Сүмбэр	83296	102815	123.4
Шивээговь	15733	13549	86.1

VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Төрөл	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Бүгд	118549	138156	116.5
Ботго	139	123	88.5
Унага	1915	1569	81.9
Тугал	2166	2452	113.2
Хурга	57049	69421	121.7
Ишиг	57280	64591	112.7

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Сумд	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Дүн	118549	138156	116.5
Баянтал	19498	22652	116.2
Сүмбэр	83282	102286	122.8
Шивээговь	15769	13218	83.8



VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Төрөл	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Бүгд	237	10005	-
Тэмээ	-	1	-
Адуу	3	279	-
Үхэр	7	403	-
Хонь	93	3628	-
Ямаа	134	5694	-

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Сумд	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Дүн	237	10005	-
Баянтал	29	1650	-
Сүмбэр	155	5444	-
Шивээговь	53	2911	-

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Төрөл	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Бүгд	113	3549	-
Тэмээ	-	-	-
Адуу	-	209	-
Үхэр	7	149	-
Хонь	43	1366	-
Ямаа	63	1825	-

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Сумд	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Дүн	113	3549	-
Баянтал	16	138	-
Сүмбэр	66	652	-
Шивээговь	31	2759	-



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, жил бүрийн эхний 4 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Нийт	12336.5	15477.8	125.5
Уул уурхайн нийт борлуулалт	14107.6	15343.3	108.8
Нүүрс олборлолт	11411.6	14457.0	126.7
Дулааны эрчим хүч, усан хангамж	905.6	999.3	110.3
Дулаан	860.1	934.9	108.7
Усан хангамж	45.4	64.4	141.8

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 4 сар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Нийт	14107.6	15343.2	108.8
Уул уурхай	13182.7	14322.5	108.6
Нүүрс олборлолт	11411.6	12192.4	106.8
Дулааны эрчим хүч, усан хангамж, сувагжуулалт	924.9	1020.7	110.4
Дулаан	860.1	934.9	108.7
Усан хангамж	45.4	64.4	141.9

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нийт үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Бүтээгдэхүүн борлуулалт /Үнийн дүнгээр, сая.төг/	14107.6	15343.2	108.8
Нүүрс борлуулалт /биет хэмжээ, мян.тн/	13182.7	14322.5	108.6
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	11411.6	14457.0	126.7
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр, сая.төг/	12336.5	15477.8	125.4
Ажиллагсадын тоо	515	595	115.5



IX.1 Авто тээврийн газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	Нэгж	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Тээврийн орлого	Мян.төг	2016.8	3971.3	194.0
Зорчигч эргэлт	Мян.хүн км	208.0	1655.9	7 дахин
Зорчигчдын тоо	Мян.хүн	7.8	7.6	97.4
Ажиллагсадын тоо	тоо	14	13	92.9

X.1 Аймгийн холбооны газрын үзүүлэлт, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	нэгж	2015 IV	2016 IV	$\frac{2016 IV}{2015 IV} \%$
Нийт орлого	сая.төг	77.2	68.0	88.0
Үүнээс: Хүн амаас	сая.төг	46.3	40.8	88.1
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	тоо	1273	1246	97.9
Телефон цэг	тоо	414	367	88.6



Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.ubseg.gov.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017